



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 315

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд
төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх
гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 05/5590 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийг хавсралтад заасан ёсоор 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 17 дугаар сарын 02-ны өдрийн
3/б дүгээр тогтоолын хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТОМИЛОГДОХ ГИШҮҮДИЙН НЭРС

Д/д	Хуулийн этгээдийн нэрс	Томилогдох гишүүдийн нэрс
1	“Монголын төмөр зам” ТӨХК	1.Ч.Батчимэг /ТӨБЗГ-ын мэргэжилтэн/
2	“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК	1.С.Баясгалан /Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга/